



61

УЛААНБААТАР
ХОТЫН ХӨДӨЛМӨРЧДИЙН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ШИИДВЭР

195 5 оны 12 дугаар сарын 24

Улаанбаатар
Дугаар 171 Хот

Хотын Халуун ус, Төв үсчний тасгуудын
ажиллагааны дүрмийг батлах тухай.

Хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны
хуралдаанаас **Т О Г Т О О Х Н Ъ:**

1/ Нийгмийн хангамжийн аж ахуйг удирдах газрын
боловсруулж ирсэн Хотын халуун ус, Төв үсчний газруудын
ажиллагааны дүрмийг баталсугай.

2/ Шинэ батлагдсан дүрмийг практик ажиллагаанд
1956 оны 1-р сарын 1-нээс эхлэн журмалсугай.

3/ 1955 оны 4-р сарын 7 ны өдрийн 52-р хуралдааны
1-р зүйлд батлагдсан үсчин халуун усны газруудын дүрмийг
хүчингүй болгосугай.



Хотын хөдөлмөрчдийн **Депутатуудын** хурлын
гүйцэтгэх захиргааны дарга

"Б. БАА"

Хариуцлагатай нарийн бичгийн дарга **Хангайз** "ДАМДИН"

Улсын ариунт цэврийн
газраас зөвшөөрөв.

62
Хотын Гүйцэтгэх захиргааны

1955 оны 12-р сарын 27 ны
өдрийн 171-р шийдвэрээр
батлав.

1955--12--27.

ХАЛУУН УСНЫ ГАЗРУУДЫН АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ.

I. Ерөнхий байдал.

1. Энэ дүрэм, Нийслэлийн хэмжээнд ажиллаж байгаа бүх халуун усны газруудад хамаарагдана.

2. Халуун усны газруудын ажиллах өдөр, цагийг хотын гүйцэтгэх захиргаанаас тогтооно.

3. Халуун усны хүлээх зал, кассын дэргэд ил үзэгдэх боломжтой газарт халуун усны ~~газрын~~ ажиллах ба амрах өдөр цагийн тухай зарлалыг бичиж хадсан байна.

Тайлбар: Баяр ба ердийн биш амралтын өмнөх өдрүүдэд халуун усны газрууд нь Хот нийгмийн хангамжийн аж ахуйнуудыг удирдах газрын баталсан тусгай хувиараар ажиллана.

4. Халуун усны газар түүний зарим тасгуудыг засварлах, үед хөдөлмөрчдөд хэвлэлээр буюу тусгай зарлал хийж, хаах хугацаа зэргийг урьдчилан мэдэгдэх ажлыг халуун усны захиргаанаас хийх ёстой.

5. Халуун усны бие ~~зугаах~~ тасалгаануудыг „Нийтийн“ „Ганцаарчилсан“ гэж ерөнхийд нь хоёр хуваана. Нийтийн баян нь „эрэгтэйчүүдийн“ „эмэгтэйчүүдийн“ гэж хоёр тусгай байна. Ганцаарчилсан баян нь „онгоцтой баян“ „онгоц-Душтэй баян“ „Душ“ Төмнөн „Эх хүүхдийн“ гэх зэргээр хувиаралсан тусгай өрөө ба усанд орогчдоос төлөх хөлс нь

харилцан өөр байх ёстой.

Тайлбар:

а/ Нийтийн ба ганцаарчилсан баян-ууд гүйцэт биш ажиллах цаг үедээ зарлиг тусгай баталсан хувиараар түр хаах явдлыг зөвшөөрөнө.

б/ Усанд орогчдын тоо олширч ажиллагаа нэмэгдэж очер олшироход хүрвэл халуун усны захиргааны даргын шийдвэрээр түр хаасан тасалгаануудыг нээх ёстой.

в/ Халуун усыг хагас ажиллагаатай байгаа үед нь цэвэрлэгээг нийтийн хүчээр хийж байвал зохино.

6. Халуун усанд /цэргийн ангиууд, сургуулийн сурагчид хүүхдийн байгууллага, нийтийн байрны хүмүүсийг усанд оруулахдаа бусад хүмүүсийг үйлчлэх явдлыг зөрчихгүйгээр нийтэд зориулсан тасгуудад зохион байгуулалттай, тогтмол өдөр, цагт зөвхөн халуун усны захиргаатай урьдчилан хэлэлцэж тохирсоноор оруулах болно.

7. Халуун усны кассууд нь халуун усны газруудын ажиллагаа эхэлэхээс 15 минутын өмнө ирж халуун усны ажиллагаа дуусахаас 1 цагийн өмнө хаана. Кассыг хааснаас хойш хүмүүсийг халуун усны газрын байшинд үл оруулана.

8. Халуун усанд орогчид нь усанд орсон, нэмэгдэл үйлчилгээ хийлэгсний хөлсийг баталсан үнийн жагсаалт ёсоор зөвхөн кассад төлнө.

/Халуун усанд орох билетийн өртөгт/
Гадуур хувтас хадаглуулсны хөлсийг орлцуулан авна.

Сургуулийн өмнөх 7 хүртлэх насны хүүхдээс хүүхдийн тоог үлб харгалзан усанд орсны үнэ авахгүй. Үнийн жагсаалтыг

кассын дэргэд ба хувтас хадаглах байранд ил газарт хадсан байна.

Тайлбар: Усанд орогчид нь худалдан авсан билет, ба мөнгөн ний хариултыг кассын дэргэд шалгах ёстой. кассаас холдсны дараа гомдол гаргавал хүлээж авахгүй болно.

9. Халуун усанд орох билетийг худалдан авсан даруйдаа ашиглах ёстой. Халуун усанд орох билетийг урьдчилан худалдаж болохгүй. Үнгэгдсэн тасарсан зэрэг шалтгаанд тохирохгүй билетийг хүчингүйд тооцно. Усанд орогчдын худалдаж авсан билетийг кассад буцааж авахгүй, ба сольж олгохгүй. Нэгэнт худалдан авсан билетээ дамжуулан худалдаж болохгүй. Тайлбар: Ямар нэг гэмтэл гарснаас халуун усыг хаахад хүрэх бол худалдан авсан билетээ тэр өдөрт нь багтаан кассад буцааж тушааж болно.

10. Халуун усанд очиргүй орох хүмүүс нь:

- а/ Хөл гар нь гэмтэж, дутуу тахир болсон хүмүүс
- б/ Жирэмсэн эмэгтэйчүүд
- в/ Хотын гүйцэтгэх захиргаанаас зориуд олгогдсон

пропусктай хүмүүс.

11. Усанд орогчдоос халуун усанд орох цагийн хэмжээ нь:

- а/ Нэгбүрчилсэн тасалгаа, онгоцны тасалгаа, онгоц ба шүршүүрт тасалгаанд орогчид нь 45 минутаас дээшгүй.
- б/ Зөвхөн шүршүүрт тасалгаанд 35 минут. тайлбар:
- а/ Дутуу тахир хүмүүст цаг хязгааргүй
- б/ Тогтоосон хугацаанаас илүү минут хэргэлсэн усанд орогчид нь кассад билетийн үнийг дахин төлнө.

12. Халуун усны эмэгтэйчүүд эрэгтэйчүүд нэг бүрчилсэн тасалгаанд хөл гаргүй, дутуу тахир хүмүүст тайчих, угаах хувьчилахад

233
65

нь үнэ төлбөргүй тусламж үзүүлэх ёстой. Эд нар нь өөрийн талын буку итгэмжилсэн хүмүүсийг дагуулж орохыг зөвшөөрөнө.

13. „Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн” тасалгаанд сургуулийн өмнөх насны хүүхэд, охидыг насанд хүрсэн хүмүүсээс дагуулан орж болно.

14. „Эхчүүд хүүхдийн” тасалгаанд сургуулийн өмнөх насны хүүхэд ба 12 хүртлэх насны охид бүхий эмэгтэйчүүдийг оруулана.

15. Сургуулийн өмнөх насны хүүхэд ба багачуудыг насанд хүрсэн хүмүүсгүйгээр нэгбүрчилсэн тасалгаанд үл оруулана.

16. Сургуулийн өмнөх ба 16 хүртлэх насны багачуудыг зөвхөн 2 цаг хүртэл усанд оруулж болно.

17. Халуун усны газрын кассад хуудас нь дугаарлагдсан байгууллагын тамга, дэргын гарын үсэгтэй „Гомдол саналын” дэвтэр байх ёстой.

„Гомдол саналын дэвтрийг” усанд орогчийн шаардсан даруй үг дуугүй авч өх хэрэгтэй.

2. Усанд орогчдын дагах журам.

1. Усанд орогчид нь халуун усанд орохоор кассаас худалдан авсан билетийг шалгагчидад үзүүлж шалгуулсны дараа үйлчлэгч хүнд тушаана.

2. Усанд орогчид нь гадуур хувтас, /польшо, малгай, горш/
зэргийг хувцасны өлгүүрт өгч хадаглуулах. Хувтсыг хүлээн аваад металаар хийсэн ноемрийг өлгөнө. Хувцас хадгалахаар авахдаа номергүйгээр авч үл болно.

Тайлбар:

а: Хувцасны өлгүүрт чимдан партфол, цунк ундаг дугуй

--5--

зэргийг хүлээн авахгүй.

а/ Усанд орогчид нь биеэн угаасны дараа үсчин, буфет зэрэг үйлчилгээний газар орохдоо хувтас тайлах, тасалгаанд эзлэх байраа суллаж өх. ёстой.

3. Усанд орогчид нь үнэнт зүйл, цаг бугуйвч, зүү, алт мөнгөн эдлэл, үнэмлэх мөнгө, түүнчилэн гадуур хувтсыг өгч үнэ хөлсийг төлж халуун усанд дежур буюу кассад хадаглуулана. Хадаглуулсан тухайд тасалбар баримт олгоно.

Усанд орогчид үнэнт зүйлээ хадаглуулаагүй бол халуун усны захиргаа үл хариуцана.

4. Усанд орогчдоос хадаглуулахаар шушаасан хувтас эдийн зүйлийг алдвал хариуцлагыг халуун усны захиргаа хүлээнэ. Хувтас алдсан тухайд халуун усны захиргаа нэн даруй акт тогтоох ёстой.

5. Усанд орогчид нь хадаглуулсан зүйлийн тасалбар, номерийг гээгдүүлбэл халуун усны захиргаанд нэн даруй мэдэгдэж үүрэгтэй. бөгөөд захиргаа нь зохих актыг тогтоож хаясан төмөр номерийн үнийг кассад хурааж хувтсыг олгоно. Тайлбар: Усанд орогч, хүн номер бүхий төмрийг гээгдүүлсэн тухай халуун усны захиргаанд мэдэгдэхээс өмнө хувтас нь алдагдсан байвал халуун усны газрын захиргаа үл хариуцана.

6. УСАНД ОРОГЧДЫН ЭРХ НЬ

а/ Бие угаах төмөн хоёрыг нэг зэрэг хэрэглэх Тайлбар: Уг төмөнг хөл толгой угаах гэдэг ялгаварыг мэдэгдэхээр тусгай бичээстэй байвал зохино.

б/ Нийтээр угаах шүршүүрийг биеэн угаахын тулд биш,

зөвхөн зайлахын тулд 3 минутаас илүүгүй хугацаагаар хэрэглэх.

в/ Хувтас тайлах газарт эмнэлгийн анхны тусламж үзүүлэх эмтэй аптвкийг үнэ төлбөргүй хэрэглэх.

1-р номерт орогчид нь алчуур, давууг үнэ төлбөргүй хэрэглэнэ. Бусад номеруудад орогчид нь Альчуур цагаан даавууг үнийн жагсаалт ёсоор хөдсийг төлж ашиглана.

7. ХАЛУУН УСАНД ОРОГЧИД НЬ:

а/ Бие угаах газар гадуур хувтастай орж болохгүй.

б/ Халуун усны газрын байшинг хир буртаг болгохгүй байх. Хувтас тайлах бие угаах халуун уурын тасалгаа, олон нийтийн хүлээх зальд, тамхи татаж үл болно.

в, Халуун усны түмпэнг хувтас тайлах тасалгаанд оруулаж хэрэглэх

г/ Хувтас тайлах тасалгааны диван дээр нойтон саван/мочалк/ бие угаах рэвен буюу олсон нэхмэл зэргийг тавьж болохгүй.

д/ Бие угаах ба шарх өрөнд шилэн эдлэл дотуур хувтас зэрэг бусад зүйлийг үл оруулана. **Е/** Халуун усны ерөө тасалгаануудад эм ба эмчилгээний зүйлүүдийг үл хэрэглэх. ийм зүйлийг төмпөн онгоцонд хийж хэрхэвч үл болно.

ж/ Халуун усны бүх өрөөнд хувтас ба ямар нэг эдлэл угааж үл болно.

3. Хувтас тайлах угаах, уураар халаах, тасалгааны сандал дээр ба төмпөн дотор үл зогсоож тусгай заасан диван суудал дээр нойтон биеэр үл хэвтэх

4. Ус гоожуулах **Царца** шүршүүр зэргийг ашигалсны дараа онгорхой орхиж үл болно. Мөн усан цөөрөмд өөрөө ус хийж үл болно.

Осол гаргахгүйн тулд насанд хүрээгүй хүүхдийг ус гоожих цоргонд ойртуулах буюу оролдуулж үл болно.

к/ Хүүхдээс бусад том хүн халуун усны төмөн дотор сууж болохгүй.

л/ Халуун усны газарт архины зүйлийг үл хэрэглэх.

м/ Цонх буюу салхивчийг дур мэдэж онгойлгож үл болно.

н/ Унаах шарах ерөөнд мачалк, цаас хог зэргийг хаяж үл болно.

8. Хэргэлсэн тоноглолын зүйлийг гэмтээсэн хүмүүс түүний сүйтгэлийг төлнөдөг.

9. Үйлчлэгч хүмүүсэд касснаас гадуур ямар нэгэн мөнгө төлөх буюу тусгай шан өгч үл болно.

9. УСАНД ОРУУЛЖ ҮЛ БОЛОХ ХҮМС НЬ:

а/ Согтуу хүмүүс.

б/ Илт харагдах арьс өнөөний өвчтэй хүмүүсийг халдваргүй гэсэн эмнэлгийн справка бичиггүй бол.

в/ Бусдын хувтсыг будах бохир хувтастай хүмүүс.

г/ Сургуулийн өмнөх насны, ^{хүүхдийг} том хүнгүйгээр үл оруулана.

3. ҮЙЛЧЛЭХ ХҮМҮҮСИЙН ДАГАХ ДҮРЭМ.

1. Үйлчлэх хүмүүс нь халуун усны газар ажиллаж байх үед усанд орогчдоос энэ дүрмийн хоёр дугаар бүлэгт заасан зүйлийг биелүүлж байгаа эсэх, ариун цэврийн ба бүх төрлийн боловсон үйлчилгээний дүрмийг биелүүлж байгаа эсэхийг хянаж шалгах ба зөрчлийг илрүүлж арга хэмжээ авахуулах санал тавих.

2. Усанд орогчдын ашигалсан онгоц, шүршүүрийн§§ ерөө тасалгааг цэвэрлэж засаад дараачийн хүмсийг үйлчилгээнд саадгүй болгоно.

234
69

Онгоцонд хүн орох бүрийн дараагаар сойзоор сойздож ариутгалын уусмалаар цэвэрлэж халуун усаар угаана. Цэвэрлээгүй өрөө тасалгаанд хүн оруулж үл болно.

3. Бие угаагч ажилчид хүний биеийг угааж өх үедээ тусгай цэвэр хормогч ~~зүүх~~ ба бусад үйлчлэгчид нь цэвэр цагаан халат усны бот өмсч хувийн ариун цэврийг сахих ёстой. Хүн ашиггалсан альчуур, / биер арьчих ~~арсан~~, цагаан даавуунд усанд орогчдод үл хэргэлж болно.

4. Саван моччалкийг тусгай шүүгээнд хадгалж зөвхөн ариутган цэвэрэлсэн моччалкийг олгож байх ёстой.

5. Усанд орогчдод ломботой альчуур даавууг олгох ёстой.

6. Үйлчлэгч бүр сар дутам эмнэлгийн үзлэгийг хийлгэж эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглүүлэх ба хувийн ариун цэврийн шаардлагыг сахих ёстой.

4. Халуун усны газрын ерөнхий журам.

1. Бие угаах тасагт угаагчийн туслалцаатайгаар биеэн угаах хүмүүст зориулан тусгай байрыг гаргана.

2. Хувтас тайлах, тасагт буцалгаж хөргөсөн савтай ус, шилэн аяга, зайлах сав тавьсан байна.

3. Хувтас тайлах тасагт нэвт салхи үлээлгэхгүйгээр байшин салживчаар салхи оруулах явдлыг халуун усны газрын эрхлэх хүмүүст хариуцуулана.

4. Халуун усны газрын байран дахь дулаан нь:

а/ Үүдний өрөө, хувтасны өлгүүрийн газар $\approx 18^{\circ}\text{C}$, хувтас тайлах өрөөнд нь 25 градус, угаах өрөөнд нь 30 градус, Уураар шарах өрөөнд 40 градус, онгоц ба шүршүүрийн өрөө нь 25 градус тус тус байна. Эдгээр өрөө бүхэнд тримометр/халууны хэмжих хэмжүүр/ байх ёстой.

5. Халуун усны газрын хариуцлагатай дежур нь үйлчлэгч нарын үүргийн биелэлт, ариун цэврийн шаардлага, ба энэ дүрмийн биелэлтэд өдөр дутам хяналт шалгалт тавьж байна. Үүргээ үл биелүүдсэн үйлчлэгчдийг халуун усны захиргаанд шилжүүлж арга хэмжээ авахуулж байна.

6. Халуун усны захиргаа нь халуун усны газрын ажлыг бүрэн хариуцажусанд орогчдыг үйлчлэх явдалтай холбогдсон бүх асуудлыг шийдвэрлэж хүмсийг чанар сайтай боловсон үйлчлэх хэвийн нөхцлийг хангах ёстой.

7. Халуун усны газрыг хааснаас хойш түүнийг цэвэрлэж байгаа хүмсээс өөр хэнийг ч тэнд үлдэхийг үл зөвшөөрөнө.

.....нийлэв.
 II% цохив Чигчийхүү